МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр Дугаар А/485 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөлд зочлох жил нэрлэсэн жилийн хүрээнд "Аи Ти Эм олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн"-д түнш аймгаар оролцох төлбөр 22.000.000 (Хорин хоёр сая) төгрөгийг Монголын аялал жуулчлалын холбоонд, үзэсгэлэнд оролцох бусад зардалд 8.000.000 (найман сая) төгрөг, нийт 30.000.000 (гучин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 30.000.000 (Гучин сая) төгрөгийг Засаг дарга дансны "Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал"–аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. "Ай Ти Эм олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн"-д аймаг орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011040